

ХБНГУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ БА МОНГОЛ- ГЕРМАНЫ ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Ц.Лхам**

ХБНГУ-ын эдийн засгийн өсөлт 2000 оноос зогсонги байдалд орсноос¹ хойш 2002 оны 3 дугаар улиралд арай сэргэх маяг орсон боловч бүрэн сэргэж чадаагүй билээ.² Үүнээс хойш 2003 оны 3 дугаар улиралд Дотоодын Нийт Бүтээгдэхүүн 0,2%-иар өссөн дүнтэй гарсан³ нь эдийн засаг сэргэж байгааг илтгэж байна. Гэвч энэ удаагийн эдийн засгийн өсөлтийг зөвхөн гадаад худалдааны өсөлт, гадаад худалдааны ашгийн дүнд л хийж чадсан⁴ гэж дүгнэж болохоор байна. Учир нь эдийн засгийн өсөлтийн нэгэн гол үзүүлэлт гэгдэх дотоодын хэрэглээ болон нийт үйлдвэрлэлийн хэмжээ хоёулаа буурсан байх жишээтэй. Өнгөрөгч 3 дугаар улиралд дотоодын хэрэглээ 1,6%, нийт үйлдвэрлэлийн хэмжээ 0,6%-иар тус тус буурсан байна.⁵ Холбооны Эдийн Засаг, Хөдөлмөрийн Яамнаас гаргасан “ХБНГУ-ын эдийн засгийн байдал” (2003 оны 11 дүгээр сарын байдлаар)-д нэгдүгээрт хэдийгээр хэрэглээний зарим нэр төрлийн барааны хувьд хэрэглээ өсөх төлөв ажиглагдаж байгаа боловч хоёрдугаарт, хэрэглээний ерөнхий байдал энэ 4 дүгээр улиралд нэмэгдэх төлөвтэй байгаа ч хэрэглэгчид харзсан, хүлээнэсэн байдалтай байж, улмаар дотоодын хэрэглээний чухал бүрэлдэхүүн болох хувийн хэрэглээ өсөхгүй байгааг дурджээ. Ийм байдал Канцлер Герхард Шредерийн Засгийн газрын хийх шинэчлэлийн дараагийн үе шатууд 2004 оноос эхлэн хэрэгжсэний дүнд ямар хөнгөлөлт, ямар нэмэлт ачаалал ирэх вэ гэдгийг хэрэглэгчид бодитоор ойлгох хүртэл үргэлжлэх төлөвтэй байгааг Хэрэглээний хэтийн төлөв, байдлыг судлах нийгэмлэгээс хийсэн сүүлчийн санал асуулгын дүн харуулж байна.⁶ Иймд шинэчлэлийг түргэвчилж, тууштай хэрэгжүүлэх явдал Германы эдийн засагт тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлэх ажээ. Канцлер Шредер 2005 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан татварын шинэчлэлийн гуравдугаар үе шатын хугацааг наашлуулж 2004 оноос хэрэгжүүлэх шийдвэр гаргасан нь үүнд сайнаар нөлөөлөх биз ээ. Германы эдийн засагт эерэг нөлөө үзүүлж буй нэгэн хүчин зүйл бол сүүлийн саруудад дэлхийн эдийн засгийн байдал сайжирч, АНУ, Европын орнууд, Япон зэрэг хөгжингүй орнуудын эдийн засаг дахин эерэг үзүүлэлттэй гарсан явдал юм.

*Ц.Лхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Ийнхүү Германы эдийн засаг сэргэж эхэлж байна гэж үзэж байгаа хэдий ч төсөв, санхүүгийн байдал хүнд хэвээр байгаа аж. 2003 онд шинээр тавих өрийн хэмжээ 18,8 млрд евро байхаар Холбооны улсын төсөвт тусгасан байсан боловч өдгөө төсвийн тодотгол хийсний дараа шинээр тавих өрийн хэмжээ 2003 онд 43,4 млрд еврод хүрэхээр байна.⁷ Бундестаг 2004 оны Холбооны улсын төсвийг 2003 оны 11 дүгээр сарын 28-нд батлан гаргасан бөгөөд уг төсөвт 29,3 млрд еврогийн зээлийг авахаар тусгасан⁸ нь 2002-2006 оны Холбооны санхүүгийн төлөвлөгөөнд төлөвлөснөөс бараг 3 дахин их байгаа бөгөөд энэ нь 2006 он гэхэд төсвийг алдагдалгүй болгож шинээр зээл авах явдлыг эцэс болгоно хэмээн амласан Шредерийн Засгийн газрыг төвөгтэй байдалд оруулж байна. Учир нь 2006 он хүртэл хоёрхон жилийн хугацаа үлдээд байхад зээл авах явдал буурах биш харин нэмэгдэж, шинээр тавих өрийн хэмжээ ихсээд байна. Гэсэн хэдий ч Шредерийн Засгийн газар Agenda 2010 хэмээх шинэчлэлийн хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ Германы эдийн засаг цаашид бүрэн сэргэснээр өрийн дарамт, төсөв санхүүгийн хямралыг давна гэдэгт итгэлтэй байгаа бололтой.

2000 оноос ХБНГУ-ын эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орсноор зардлыг хэмнэх бодлогыг баримталсаар ирсэн нь хөгжлийн хамтын ажиллагааны салбарыг ч бас тойрсонгүй. Холбооны Засгийн газар 2000 оны 6 дугаар сараас эхлэн төсөв хэмнэх, Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яамнаас хэрэгжүүлж буй бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хөгжлийн тусламж олгож буй түнш орнуудтайгаа хамтран ажиллах асуудлыг зарчмын хувьд эргэн харах, шинэчлэн зохион байгуулах, хөгжлийн тусламжийг цөөн тооны салбарт төвлөрүүлж, үр ашгийг дээшлүүлэх хэмнэлтийн бодлогыг явуулах болсон. Энэ бодлогын дүнд хөгжлийн тусламж олгодог түнш орнуудын тоог 118-аас 80 хүртэл цөөрүүлж, уг жагсаалтанд үлдсэн орнуудад үзүүлэх тусламжийн хэмжээг 10-30%-иар бууруулсан ажээ.⁹ Гэтэл Холбооны Засгийн газар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжийнхаа хэмжээг сүүлийн жилүүдэд ерөнхийдөө бууруулаагүй харин ч нэмсээр ирсэн нь ХБНГУ-аас манай улсын хувьд явуулж буй бодлогын нэг илрэл гэлтэй.

ХБНГУ-аас Монгол Улсад үзүүлсэн хөгжлийн тусламжийн хэмжээ

	1991 /сая DM/	1992 /сая DM/	1993 /сая DM/	1994 /сая DM/	1995 /сая DM/	1996 /сая DM/	1997 /сая DM/	1998/1999 /сая DM/	2000/2001 /сая евро/	2002/2003 /сая евро/	Нийт 1991- 2003 /сая евро/
Санхүүгийн хамтын ажиллагаа	15	10	14	17	12	15	15	25+17 ⁱⁱ	20+ 8 ⁱⁱⁱ	10	95.90
Техникийн хамтын ажиллагаа үйсээн чилгээлээр	9	5	11	11	13	14	15	25+3 ^{iv}	20+ 6 ^v	10+1 ^{vi}	78.49
Дүн	24	15	25	28	25	29	30	70	54 /108 сая гаруй DM /	21 /60 сая орчим DM/	174.39
Техникийн тусламж бусад чилгээлээр											27.10
Нийт Дүн											201.49

- i 1998 оноос эхлэн 2 жилээр амладаг болсон.
- ii Ерөнхийлөгч Роман Херцогийн айлчлалын үеэр 17 сая DM нэмж амласан
- iii Засгийн газар хоорондын хэлэлцээний амлалтаас гадуур 8 сая DM-ыг “Сэргээгдэх эрчим хүч” төсөлд зориулан тусгайлан амласан /2001/
- iv Роман Херцогийн айлчлалын үеэр Эрх зүйн зөвлөлгөө өгөх төсөлд зориулж 3 сая DM нэмж амласан.
- v Засгийн газар хоорондын хэлэлцээнээс гадуур зудын гамшигт 2 сая DM, мөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад 4 сая DM-ийг зориулж олгосон.
- vi Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яамны парламентын төрийн нарийн бичгийн дарга У.Айдын айлчлалын үеэр хуулийн мэргэжилтнүүдийг давтан сургах төсөлд 1 сая евро амласан.

Эх сурвалж: Монгол Улсын Санхуу, Эдийн Засгийн Яам

Үүнээс үзэхэд энэ бодлого юутай ч гэсэн Монгол Улсыг дэмжсэн бодлого болох нь илэрхий байна. Аливаа нэг субъектээс нөгөө субъектын талаар явуулах бодлогын цаана ямагт бодит сонирхол гэдэг хүчин зүйл шийдвэрлэх гол үүрэг гүйцэтгэж байдаг билээ. Тэгвэл ХБНГУ-аас Монголын талаар явуулж буй өнөөгийн бодлогын цаана орших бодит сонирхлын талаар зарим судлаачдын үзэж буйгаар ХБНГУ нь Монгол Улсын хувьд ямар нэгэн бодит сонирхол байхгүй гэдэг.

Үүнийг Бундестагийн гишүүн Фридрих Остын хэлсэн үг зарим нэг талаар батлах мэт. Тэрээр «Монголын талаас “Герман Өргөө” буюу “Дойчес Хаус”-ыг Улаанбаатарт байгуулахыг Германы талд удаа дараа хүсэлт болгож байсан бөгөөд энэ нь Монголд Германы эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах, идэвхжүүлэхэд тулах гол төв болох ёстой гэж үздэг юм билээ. Хэдийгээр одоохондоо Улаанбаатарт Германы аж үйлдвэр, худалдааны төв юм уу “Дойчес Хаус” байгуулах эдийн засгийн бодит шаардлага, боломж байхгүй ч гэсэн энэ санал ирээдүйд хэрэгжих төсөл хэвээрээ байг гэж би бодож байна» гэжээ.¹⁰ Нөгөө талаар ХБНГУ-ын Гадаад Яамнаас 2002 оны 5 дугаар сард Зүүн Азийн орнуудад явуулах Германы гадаад бодлогын зорилтууд хэмээх баримт бичигт “Герман, Монголын худалдааг дэмжих тухайд зөвхөн хязгаарлагдмал боломжтой юм” хэмээн бичсэн нь бий.¹¹

Уг баримт бичигт Монгол Улс нь ардчилсан улс гэдгийг онцлон тэмдэглэсэн байх бөгөөд “Орос, Хятадын дунд «сэндвич» шиг геополитикийн байрлалтай ардчилсан Монгол Улсыг бие даасан гадаад бодлого явуулахад дэмжлэг үзүүлнэ” гэжээ. Монгол дахь ардчилал бол нэг талаас хоёр орны хамтын ажиллагааны бат бэх суурь төдийгүй нөгөө талаас Германы Монгол дахь цорын ганц сонирхол байх талтай юм.

Ер нь аливаа хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хоёр урсгалтай, харилцан ашигтай бус харин нэгээс нөгөөд чиглэсэн ганцхан урсгалтай байх тохиолдолд явцгүй байдаг билээ. Тэгвэл бид хоёр талын хамтын ажиллагааны төвшинг дээшлүүлсээр эдүгээ Монгол-Германы харилцааг иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүргэхээр чармайж буй өнөөгийн нөхцөлд зайлшгүй нэг зүйлийг бодох ёстой бөгөөд энэ нь хоёр талын харилцааг явал хоёр урсгалтай болгох вэ гэдэг асуудал юм. Үүнд л судалгаа, шинжилгээний ажлын үр дүн орших биз ээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Agenda 2010. Deutschland bewegt sich. Hrsg. Presse- und Informationsamt der Bundesregierung. November 2003. Seite 6 <http://www.bundesregierung.de/Anlage557980/Agenda+Brosch%fcrcr.pdf>
2. Die wirtschaftliche Lage in der Bundesrepublik Deutschland. November 2003. Hrsg. Bundesministerium für Wirtschaft und Arbeit. Seite 1
3. МӨН ТЭНД
4. “Nur der Export zieht die deutsche Wirtschaft aus dem Minus.” Frankfurter Allgemeine Zeitung, 21.11.2003, Nr. 271/Seite 14
5. Die wirtschaftliche Lage in der Bundesrepublik Deutschland. November 2003. Hrsg. Bundesministerium für Wirtschaft und Arbeit. Seite 5, 7
6. Die wirtschaftliche Lage in der Bundesrepublik Deutschland. November 2003. Hrsg. Bundesministerium für Wirtschaft und Arbeit. Seite 7
7. Neuverschuldung des Bundes steigt auf 43,4 Milliarden Euro. Mi, 26.11.2003-12-02 <http://www.bundesregierung.de/-413.545896/artikel/Neuverschuldung-des-Bundes-ste.htm>
8. Bundeshaushalt 2004: Konsolidierung und Wachstum. Fr, 28.11.2003. <http://www.bundesregierung.de/-413.56761/artikel/Bundeshaushalt-2004-Konsolide.htm>
9. “Герман: Судалгаа, мэдээлэл сэтгүүл”, №1(1) 2002. Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаа. Санхүү, эдийн засгийн дэд сайд, доктор, профессор Л. Энхтайван
10. Гадаад харилцаа (Монгол Улсын Гадаад Хэргийн Яамны мэдээллийн товхимол) №11(106) 2001. 10.15; Фридрих Ост “Шилжилтийн үеийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлууд”
11. Aufgaben der deutschen Außenpolitik am Beginn des 21. Jahrhunderts. Ostasien (Japan, Süd- und Nordkorea, Mongolei, China einschließlich Hongkong und Macau, Taiwan), Hrsg. Auswärtiges Amt der BRD. Berlin Mai 2002